

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Жилийн Ерөнхий Хуралдааны талаар

ОУДС-ийн жилийн ерөнхий хуралдаан 10 сарын 8-ны Пүрэв гарагт сургууль дээр 19:00 цагт болно. 18:00 цагаас санхүүгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл сонирхсон хүмүүст зориулж товч хурал хийнэ. 10 сарын 8-ны орой та бүхэн хүрэлцэн ирж хуралдаа оролцоно гэдэгт миний бие болон сургуулийн Удирдах Зөвлөлийн хамт олон итгэлтэй байна. Удирдах Зөвлөлд сонгогдохоор нэрээ дэвшүүлсэн эцэг эхчүүдийн талаарх мэдээлэлийг бид та бүхэнд хүргэж байна. Энэ мэдээлэлийг та бүхэн сайтар уншаарай. Ирэх долоо хоногт бид санхүүгийн товч тайланг ОУДС-д электрон шуудангийн хаягаа бүртгүүлсэн эцэг эхчүүдэд e-мэйлээр хүргэх болно. Та бүхэн хуралд биеэр ирж чадахгүй бол Мэдээнд хавсаргасан хуудсыг бөглөж таныг төлөөлөн санал өгөх хүнийг сонгоорой. Бөглөсөн хуудсаа сургуулийн ресепшин дээр байгаа цоожтой хайрцганд хийж болно.

Эцэг эхчүүд та нар Жилийн Ерөнхий Хуралдаанд хүрэлцэн ирсэнээр хүүхэддээ 5 house point авч өгөх боломжтой. Та бүхэн хуралд ирж оролцох буюу таныг төлөөлөн санал өгөх хүнийг томилох нь чухал. Зөвлөлийн дүрэмд зааснаар нийт гишүүдийн 25 хувь буюу 72 эцэг эх хуралд оролцож байж хурал хүчин төгөлдөр болж санал хураах эрхтэй. Хурлын үеэр бид та бүхэнд хөнгөн зуушаар үйлчилнэ.

ШИНЭ АЖИЛТНУУД

Манай сургуульд өчигдөр шинээр 2 ажилтан орлоо. Дэнзэндолгор Бага Сургуулийн Биеийн Тамир, Зургийн туслах багшаар, Сараа манайд сувилагчаар ажиллана. Манай сургуульд шинээр 2 хүн ажилд орсонд бид баяртай байна.

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД

10 сарын 8	ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ХУРАЛДААН – 19:00
10 сарын 14	1-р улирлын дугуйлангууд хичээллэж дуусна
10 сарын 16	1-р улирлын хичээл дуусна
10 сарын 17	1-р улирлын амралт эхэлнэ
10 сарын 28	Намрын амралт дуусч 2-р улирлын хичээл эхэлнэ

Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй.

Захирал
Greg Rayl

СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,

ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүдийн өмнөөс би та бүхэнд шинэ хичээлийн жилийн мэнд хүргэе! Манай Жилийн Ерөнхий Хуралдаан 2009 оны 10 сарын 8-ны Пүрэв гарагт 19 цагт болно.

Энэ жилийн ерөнхий хуралдаан нь ОУДС-ийн хамт олон бидэнд олсон ололт амжилтаа дүгнэж ирээдүйгээ төлөвлөх сайхан боломжийг олгодог юм. Энэ хуралдаанаар Сургуулийн Удирдах Зөвлөлийн шинэ гишүүдийн сонгууль явагддаг. Удирдах Зөвлөлийн гишүүд 2 жилийн хугацаатай сонгогддог. ОУДС-ийн сурагчдын бүх эцэг эхчүүд (тус сургуульд ажилладаг эцэг эхчүүд сонгуульд оролцохгүй) болон сурагчдын хууль ёсны асран хамгаалагчид энэ сонгуульд оролцож сургуулийг удирдах үйлчлэлд хувь нэмрээ оруулах боломжтой.

Хэрвээ та бүхэн Жилийн Ерөнхий Хуралдаанд оролцох боломжгүй бол таныг төлөөлж санал өгөх хүн томилж байгаа тухайгаа бичгээр бөглөж сургуулийн Ресепшинд авчирч өгөх буюу 10 сарын 8-нд хуралд оролцох эцэг эхээр дамжуулж өгч болно. Энэ хуудсыг бид Мэдээнд хавсаргасан болно.

Та бүхнийг хүндэтгэсэн

ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн Дарга

Shane Rosenthal

shane.rosenthal@gmail.com

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Энэ долоо хоногт цаг агаар дулаахан сурагчид маань завсарлагааны цагаа намрын нар ээсэн үед өнгөрөөж байгаадаа баяртай байна. Өглөөгүүр сэрүүн орсон тул та бүхэн хүүхдүүдээ цаг агаарт тохируулж дулаан хувцаслаарай. Үүнтэй уялдуулан сурагчид ус их хэмжээгээр уух шаардлага гарч байна. Сүүлийн үед сурагчдын толгой өвдөх болсон нь шингэн дутагдсаны анхны шинж тэмдэг юм. Монгол оронд намар цаг аль хэдийн ирсэн ч нар хурцаар шарж, агаарын чийгшил бага, хуурайшилт ихтэй байгаа тул та бүхэн эрүүл мэнддээ анхаарч шингэн юм их уух хэрэгтэй.

Сурагчдын Зөвлөл хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулж, Yearbook багийхан сурагчдын зургийг авч дууслаа. Долоо хоног болгон сурагчдын дунд арга хэмжээ зохиогдож байгаа тул та бүхэн Мэдээгээ болон манай вэб сайтыг тогтмол уншиж байгаарай. Эцэг эхчүүд та нарт болон сурагчдад хэрэгтэй мэдээллүүд энд байнга тавигддаг. ЭБЗ сар болгоны эхний долоо хоногийн Мягмар гарагт хурлаа хийдэг. Та бүхэн хуралд ирж оролцоорой. Энэ жил Verit Aadnanes, Kai Berg нар Эцэг Эх Багш нарын Зөвлөлийг хамтран даргалж байгаа. ЭБЗ-с зохион байгуулдаг олон арга хэмжээнд та бүхэн саналаа нэмэрлэж дэмжлэг үзүүлж ажиллаарай.

10 сарын 1-ний Пүрэв гарагт болсон МҮР хөтөлбөрийн талаар мэдээлэл хийсэн уулзалтанд та бүхэн ирж оролцсон гэдэгт бид итгэлтэй байна. Та бүхэн надтай буюу Mr. Chilton-той холбоо барьж бидэнд санал хүсэлтээ ирүүлээрэй. Хичээлийн жилийн туршид бид та бүхэнд дэлгэрэнгүй мэдээлэл хийж гэртээ хүүхдүүдээ дэмжиж ажиллахад тань туслах болно. 10 сарын 8-ны Пүрэв гарагт манай сургуулийн Жилийн Ерөнхий Хуралдаан болно. Та бүхэнтэй энэ хурлын үеэр уулзацгаая!

Дунд Сургуулийн Эрхлэгч

Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

5-р ангийн сурагчид Баян Зүрх дүүргийн гэр хороололд зочилсон аялалаа төсөл болгон хэрэгжүүлэх тал дээр энэ долоо хоногт завгүй ажиллалаа. Гэр хорооллын айлуудын амьдралд нэмэр болох төсөл хийхээр ажиллаж Mrs. Griffeth-н зөвлөсөний дагуу хэд хэдэн төсөл боловсрууллаа. Мягмар гарагт тэд өөрсдийн боловсруулсан төслөө ЭБЗ-ийн хуралд өргөн барьсан бөгөөд ЭБЗ аль төслийг нь дэмжихээ шийдэх юм. Намрын Баяраар цуглуулсан хандиваар энэ төслийг санхүүжүүлэх болно. Пүрэв гарагт болсон бага сургуулийн өдөрлөгөөр 5-р ангийн сурагчид өөрсдийн хийсэн аялал болон төслүүдийн талаарх танилцуулгыг Бага Сургуулийханд сонирхууллаа.

Унтлагын Хувцасны Өдөр: Бага сургуулийн олон сурагчид өнөөдөр хичээлдээ унтлагын хувцастайгаа ирсэн боловч ангидаа унтах зав гарсангүй.

Зургийн танхимд хуучин сонин хэвлэл ирүүлсэн гэр бүлийнхэндээ баярлалаа. Бидэнд сонин сэтгүүлүүд байнга хэрэг болдог.

Олон Улсын 7 хоног: Каллиграфт (Хятад, Монгол, Япон, Солонгос) авьяастай эцэг эхчүүд буюу сурагчдын садан төрлийн хүмүүс энэ авьяасаа олон улсын 7 хоногийн өдрүүдээр зургийн хичээлийн үеэр ирж бидэнтэй хуваалцах хүсэлтэй бол энэ тухайгаа бидэнд мэдэгдэнэ үү.

Ариун Цэврийн талаар: Сүүлийн өдрүүдэд хэд хэдэн сурагчийн гэдэс өвдөх асуудал гарлаа. Халдвараас сэргийлэх хамгийн үр дүнтэй энгийн арга бол гараа тогтмол угаах явдал юм.

Шинэ Ажилтан: Дэнзэндолгор манай бага сургуулийн зураг, биеийн тамирын туслах багшаар ажиллана.

ЭБЗ-ийн мэдээ

Энэ 7 хоногт болсон хурал дээр Баян Зүрх Дүүргийн гэр хорооллын өрхүүдийг дэмжих зорилгоор 5-р ангийн сурагчдын боловсруулсан төслүүдтэй гишүүд танилцлаа.

10 сарын 6-ны Мягмар гарагт 3 цагаас Номын Санд дараагийн хурал болно. Энэ хурлаар Баян Зүрх Дүүргийн гэр хороололд хэрэгжих төслийг санхүүжүүлэх шийдвэр гаргана. Олон орны Хоолны Өдөрлөгийн Зохион байгуулалтын асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

Бага Сургуулийн Эрхлэгч
Jan Wiggins

БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

Намрын амралтын дараа Нинбо хотноо болох АСАМIS волейболын тэмцээнд оролцох охид, хөвгүүдийн баг тамирчдын нэрс тодорлоо. Ирэх 2 долоо хоногийн туршид багууд Америкийн Сургууль болон Хобби Сургуулийн багуудтай тэмцээн зохионо.

Хөвгүүдийн баг: (сурлагын амжилтаас хамаарна)

Vasek (Багийн Ахлагч), Derryn, Jiri, Beom Su, Мэргэнзаяа, Christian, Мишээл, Seung Kyu, Joona, Билэгт

Охидын баг:

Mila (Багийн ахлагч), Reeza, Намуун, Бадамханд, Энхээ, Zina, Nalini, Удвал, Байгал

Бэлтгэлийн хуваарь:

Охидын баг Мягмар, Пүрэв гарагуудад 4:00-5:30

Хөвгүүдийн баг Лхагва гарагт 4:00-5:30, Бямба гарагт 1:00-3:00

Сургуулийн хөл бөмбөгийн тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Олон үзэгчид ирж олон гоол орсон тэмцээн болж өнгөрлөө. Багийн ахлагчид багуудаа сайн зохион байгуулж оролцсон бөгөөд Цэнхэр баг бусдаасаа илүү хүчтэй өрсөлдөгч болохоо харуулж чадлаа. Цэнхэр багийн эсрэг Улаан, Шар багууд хүч тэнцүү өрсөлдсөн ч ялагдал хүлээлээ.

Тоглолтын оноог Англи эх хувиас харна уу.

Хамгийн олон гоол оруулсан сурагчид:

Tiffany-11, Justine-7, Amina-5, Sabrina-2

10 сарын 3-ны Бямба гарагт 9-12-р ангийн охидын багийн волейболын тэмцээн болно. Тэмцээн 10 цагт эхэлж 12 цагт дуусна. Хөгжөөн дэмжигчид та бүхэн ирж тэмцээн үзээрэй. Ирэх долоо

хоногийн Бямба гарагт 10 сарын 10-нд сургууль дээр SAT шалгалттай тул спортын тэмцээн болохгүй.

9-12-р ангийн багийн ахлагчид:

	Хөвгүүдийн баг	Охидын баг
Цэнхэр Баг	Тайван	Josephine
Ногоон Баг	Seung Kyu	Сарантөгс
Улаан Баг	Vacek	Байгал
Шар Баг	Derryn	Hiba

**Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч
David Ricketts**

СУРАГЧДЫН ЗӨВЛӨЛӨӨС

Өнгөрсөн Баасан гарагт Дунд ангийн сурагчдад кино үзүүлэх арга хэмжээнд оролцсон бүх хүмүүст баярлалаа. Та бүхэнд манай кино таалагдсан гэдэгт бид итгэлтэй байна.

Сурагчдын Зөвлөлөөс зохиож буй арга хэмжээг тарахад сурагчдыг авах унааг цагт нь бэлэн байлгахыг нийт эцэг эхчүүд та бүхэнд анхааруулж байна. Бидний зохион байгуулдаг арга хэмжээ ихэвчлэн Баасан, Бямба гарагийн орой болдог тул арга хэмжээг зохион байгуулж ажиллаж байгаа хүмүүсийг цагт нь хариулахын тулд та бүхэн зөвшөөрлийн хуудсан дээр бичигдсэн сурагчдыг тарахад нь авах цагийг хатуу баримталж байх хэрэгтэй.

ОУДС-ийн Сурагчдын Зөвлөлийн ажлыг дэмжиж оролцдог та бүхэнд талархал илэрхийлье.

**Сурагчдын Зөвлөлийн Тэргүүлэгч
Hiba Sayed**

Ахлах Сургуулийн Сурагчдын Кино Үзвэр

10 сарын 9-ний Баасан гарагт Сурагчдын Зөвлөл ахлах ангийн сурагчдад кино үзүүлнэ. Энэ үеэр та бүхэн Coraline and Fast and Furious 4 кинонуудыг үзэх болно. Кино оройн 6 цагт эхэлж 7:45-д дуусна. Та бүхэн хүүхдээ 7:30-с хоцролгүй авах унааг нь зохицуулаарай. Үзвэрийн билетний үнэ 3000 төгрөг. Кино үзэх зөвшөөрлийн хуудсаа 10 сарын 6-ны Мягмар гарагт буцааж ирүүлээрэй. Үзвэрийн үнэнд ундаа, попкорн багтсан бөгөөд сурагч бүр нэг кино сонгож үзэх боломжтой. Манай сургуульд сурдаггүй гадны сурагчдыг үзвэрт оруулахгүй болохыг анхаарна уу.

Та бүхэнд баярлалаа.

ОУДС-ийн С урагчдын Зөвлөл

**ОУДС-ийн Удирдах Зөвлөлд сонгогдохоор саналаа ирүүлсэн
Нэр Дэвшигчдийн товч танилцуулга**

- 1. Oddvar Aadnanes.** NLM (Norwegian Lutheran Mission) Байгууллагын Монгол дахь Салбарын Захирал. Монголд 2007 оноос ажиллаж амьдарч байгаа. 2012 он хүртэл Монголд ажиллах гэрээтэй. Хүний их эмч мэргэжилтэй. 5–н хүүхдийн 4–нь тус сургуульд сурдаг: Elise 10-р анги, Kristian 8-р анги, Isak 5-р анги, David 3-р анги. Эхнэр Berit Aadnanes ОУДС-ийн Эцэг Эх Багш нарын Зөвлөлийн даргын сонгуульд ажилтай. Ноён Aadnanes ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 2. Layton Croft.** Айвенхоу Майнз Компаний Дэд Ерөнхийлөгч. ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн Гишүүн. Удирдах Зөвлөлд 2005, 2007 онд гишүүнээр сонгогдсон. Удирдах Зөвлөлийн Дэд даргаар ажиллаж байсан. Хүү Чандмон тус сургуулийн 3-р ангид, хүү Sky бэлтгэл ангид тус тус сурдаг. Ноён Croft ОУДС-ийн Удирдах Зөвлөлд 3 дахь удаагаа сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 3. Dr.Nalin Sharma Govind.** Улаанбаатар дахь гудамжны хүүхдүүдэд туслах төсөл хэрэгжүүлдэг Төрийн Бус Байгууллагад ажилладаг. 2006 оноос Монгол оронд ажиллаж байгаа. Сэтгэцийн эмч мэргэжилтэй. Охин Nitika тус сургуулийн 6-р ангид сурдаг. Хатагтай Govind ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 4. John Karlsen.** Вагнер Ази компанийн Ерөнхий Захирал. Монголд 1996 оноос ажиллаж амьдарч байгаа. Монголын Хүүхдийн Тусламжийн Сангийн ерөнхийлөгчийн сонгуультай. Охин Andrea, хүү Алтай нар нь тус сургуулийн цэцэрлэгийн ангид сурдаг. Ноён Karlsen ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 5. Sun-Jeong Kim.** Монголын Шашны Урлагийн Ухааны Дээд Сургуулийн Орлогч Захирал, Монголын Уламжлалт Урлагийн Ухааны Соёлын Төвийн Гүйцэтгэх Захирал. Охин Анхаа Хаанаа тус сургуулийн 10-р ангид сурдаг. Хатагтай Kim ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 6. Sejoon Oh.** Sky Resort Компаний Дэд Ерөнхийлөгч. 2000-2004 онд Sky C&C компаний Дэд Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. Хүү Sung Kuu тус сургуулийн 10-р ангид сурдаг. Ноён Oh ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 7. David Reiner.** ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүн. 2007 онд УЗ-ийн гишүүнээр сонгогдсон. Mongolian Star Melchers Компаний Захирал. Сүүлийн 15 жилд Азийн орнуудад үүний дотор Монголд 10 гаруй жил ажиллаж амьдарч байна. Охин Сарнай тус сургуулийн 4-р ангид сурдаг. Ноён Reiner ОУДС-ийн Удирдах Зөвлөлд 2 дахь удаагаа сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.

**ОУДС-ийн Удирдах Зөвлөлд сонгогдохоор саналаа ирүүлсэн
Нэр Дэвшигчдийн товч танилцуулга (үргэлжлэл)**

- 8. Дашдаваагийн Хулан.** Таван Богд Компаний Дэд Ерөнхийлөгч. Охин Баатарсайханы Сийлэн ОУДС-г 2009 онд төгсөж Канадын Douglas College-д суралцах гэж байна. Хүү Баатарсайханы Амарсайхан тус сургуулийн 6-р ангид сурдаг. Хатагтай Хулан ОУДС-ийн Удирдах Зөвлөлд шинээр сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.
- 9. Чүлтэмийн Мөнхцэцэг.** ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүн. Удирдах Зөвлөлд 2005, 2007 онд гишүүнээр сонгогдсон. Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Хүү Дөлгөөн ОУДС-ийг 2009 онд төгссөн. Хүү Дархлан тус сургуулийн 3-р ангид сурдаг. Хатагтай Мөнхцэцэг ОУДС-ийн Удирдах Зөвлөлд 3 дахь удаагаа сонгогдохоор нэрээ дэвшүүлээд байна.